



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2003 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 509

Улаанбаатар хот

ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЦИЙГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, , Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 185 дугаар тогтоолын 5 дугаар заалт, 2003 оны 201 дүгээр тогтоолыг болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай тохиролцсоныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг Төрийн захиргааны хэлтэс / Аж ахуйн тасагтай/ Санхүү, эдийн засаг, төрийн сангийн хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Тохижилт үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс, Цэргийн болон гамшигаас хамгаалах штабтай байхаар тогтоосугай.

Хоёр. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын ажлын байрны үлгэрчилсэн жагсаалтыг шинэчлэн хавсралтын дагуу баталсугай.

Гурав. Тамгын газрын хэлтэс, тасгийг батлагдсан бүтцийн дагуу ажиллуулж, Засгийн газраас тогтоосон орон тооны хязгаарыг чанд мөрдөхийг дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.


Дөрөв. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2000 оны 423 дугаар захирамжийн тавдугаар заалтын 10-т заасан “Спорт сургалтын төв”-гэснийг “Биеийн тамир спортын хороо”, 11-д заасан “Халамжийн төв”- гэснийг “Нийгмийн халамж үйлчилгээний төв”- гэж өөрчилж хоёрдугаар заалтын Тамгын газрын бүтцийг тогтоосон хэсэг, гуравдугаар заалт мөн тавдугаар заалтын 5,7 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД

0201489



Нийслэлийн Засаг даргын 2003 оны
509 зурагийн захирамжийн хавсралт

ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АЖЛЫН БАЙРНЫ ҮЛГЭРЧИЛСЭН ЖАГСААЛТ

Нэг. Төрийн захиргааны хэлтэс /Аж ахуйн тасагтай/

- Тамгын газрын дарга бөгөөд Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
- Хэлтсийн орлогч дарга бөгөөд боловсон хүчний асуудал хариуцсан зохион байгуулагч
- Дотоод ажил хариуцсан зохион байгуулагч
- Хууль, эрх зүйн асуудал хариуцсан зохион байгуулагч
- Засаг даргын туслах
- Хороо хариуцсан зохион байгуулагч
- Шагнал, хэвлэл мэдээлэл, гадаад харилцааны асуудал хариуцсан зохион байгуулагч
- Өргөдөл гомдол, захиргааны хяналтын асуудал хариуцсан зохион байгуулагч
- Иргэний гэр бүлийн бүртгэлийн асуудал хариуцсан зохион байгуулагч
- Иргэний бичиг баримт, шилжилт хөдөлгөөний асуудал хариуцсан зохион байгуулагч
- Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан зохион байгуулагч
- Аж ахуйн тасгийн дарга
- Ахлах ня-бо
- Аж ахуйн нярав
- Архив, бичиг хэргийн эрхлэгч
- Бичээч

Хоёр. Санхүү, эдийн засаг, төрийн сангийн хэлтэс

- Хэлтсийн дарга
- Ерөнхий ня-бо
- Төсвийн мэргэжилтэн
- Бүртгэлийн мэргэжилтэн
- Орлого, эдийн засгийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Банкны, төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн

ТАЙЛБАР: Нормативт орон тоо болох байгууллагуудын төлбөр, тооцоо, хариуцсан мэргэжилтэн: /Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан дүүрэгт тус бүр- 3, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт тус бүр- 2, Налайх, Баганур, Багахангай дүүрэгт тус бүр- 1 байна.

Гурав. Тохижилт, үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс:

- Хэлтсийн дарга
- Худалдаа, нийтийн хоолны асуудал хариуцсан зохион байгуулагч
- Нийтийн аж ахуй, тохижилтын асуудал хариуцсан зохион байгуулагч
- Хөдөө аж ахуй, байгаль орчны асуудал хариуцсан зохион байгуулагч
- Жижиг, дунд үйлдвэр, ахуйн үйлчилгээ хариуцсан зохион байгуулагч
- Дэд бүтэц, тохижилтын асуудал хариуцсан зохион байгуулагч

Дөрөв. Нийгмийн хөгжлийн хэлтэс

- Хэлтсийн дарга
- Сургууль, цэцэрлэгийн асуудал хариуцсан зохион байгуулагч
- Эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, спортын асуудал хариуцсан зохион байгуулагч
- Хүүхэд, залуучууд, соёлын асуудал хариуцсан зохион байгуулагч
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан зохион байгуулагч

Тав. Цэргийн болон гамшгаас хамгаалах штаб

- Штабын дарга
- Цэрэг, техникийн тоо бүртгэл, нөхөн хангарт хариуцсан офицер
- Иргэний хамгаалалтын бэлтгэл, бэлэн байдал хариуцсан офицер